



САНГИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А294

Улаанбаатар хот

“Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлэх  
нэгжийн тухай

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийн хуваарь 2-ийн 1 дүгээр хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Экспортыг дэмжих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулж, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үүргийг “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэгч нэгжид давхар хариуцуулсугай.

Хоёр. “Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлэх гарын авлагыг боловсруулж, төслийг хэрэгжүүлэгч болон санхүүжүүлэгч талуудаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Төсөл хэрэгжүүлэгч нэгж (Д.Батмөнх)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газар, Санхүүгийн бодлогын газарт үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Б.НЯМАА

001019